

ЯПОНЫ ЛИБЕРАЛ АРДЧИЛСАН НАМ, ТҮҮНИЙ ЛИДЕРҮҮД

*К.Дэмбэрэл**

Японыг барууны хэлбэрийн ардчилалд оруулах “Загалмайтны аян дайн” түүнийг коммунизмын эсрэг эвслийн зүүн цэг болгон хувиргасан.

Киси Нобусукэ /Сато/ бол төрөлхийн үндсэрхэг үзэлтэн, нэг хэсэг ХҮЯ-нд дараа нь Манжго-ийн засгийн газрын 2 дахь хүн нь байсан. Түүний дараа ХҮЯ-ны дэд сайд, сайд, дайны гэмт хэрэгтэн, 3 жил 3 сар шоронд ч суусан ба “хүйтэн дайны” ачаар суллагдаж улс төрд дахин хүчээ үзэж болсон. Тухайн үед эрх барьж байсан Либерал Намд орж тун удалгүй тэнд фракц байгуулан намынхаа эсрэг үйл ажиллагаа явуулсан тул хөөгдсөн. Киси 1953 оны 11-р сарын 24-нд Ардчилсан Намыг зохион байгуулж, түүний ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдсон. 1955 онд АНУ-д нэг хэсэг явж нийгэм, улс төр, цэргийн томоохон зүтгэлтнүүдтэй уулзан, хоёр орны хоорондын цэрэг улс төрийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх талаар хүчин зүтгэж эхэлсэн ба барууны консерватив хүчнүүдийн хоорондын эвслийг ихэд сайшаах болсон. 1955 оны 11-р сарын 15-нд Либерал Нам, Ардчилсан Намыг нэгтгэж Либерал Ардчилсан Нам-(ЛАН)-ыг зохион байгуулж түүний ерөнхий нарийн бичгээр сонгогдсон.

1957 оны 2-р сарын 27-нд Киси ЛАН-ын лидерүүдийн хаалттай уулзалтаар ерөнхий сайдын суудалд заларч 10-н жилийн дотор дайны гэмт хэрэгтнээс ерөнхий сайд болж өвөрмөц амжилт гаргасан улс төрч. АНУ-Японы аюулгүй байдлын хамтын ажиллагааны гэрээнд 1960 оны 1-р сарын 19-нд Цагаан Ордонд очиж Киси ерөнхий сайдын хувьд гарын үсэг зурсан. Олон нийтийн эсэргүүдэл хүчтэй байсан учир 1960 оны 6-р сарын 23-нд огцорсон. 1960 оны 7-р сарын 14-нд Икэда Хаятог ерөнхий сайд болсныг тохиолдуулан ЛАН-аас зохион байгуулсан хүлээн авалт дээр хэт барууны үзэлт Арамаки Тайсукэ, Кисиг цохиж хүчтэй гэмтэл учруулсан нь түүнийг хоёр долоо хоног эмчлүүлэхэд хүргэсэн.

* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Сөрөг хүчинтэй “хэл амаа” ололцохын төлөө байсан ЛАН-ын лидерүүдийн нэг бол ерөнхий сайд Икэда Хаято байсан. Барууны орнуудад Японы нэр төрийг өргөж, экспортыг нэмэгдүүлэх талаар айлчлал хийж байх үед Шарль де Голль түүнийг “транзисторын наймаачин” хэмээн хэлсэн нь түүнд маш эвгүй сэтгэгдэл төрүүлсэн. Харин хорин жилийн дараа Ф.Миттеран Япончуудаас суралцахыг уриалж байсан тал бий. 1960 оны 10-р сарын 12-нд ЯСН-ын лидер Асанума Инэдзирог Японы Эх орны фашист намын гишүүн 17 настай Ямагучи Отая 2 удаа хутгалсан. Ер нь Икэда зүүнийхэнд “хэт зөөлөн” хандаж байна гэсэн шүүмжлэлийг хэт барууныхны зүгээс байнга сонсох болсон. Түүнд ЛАН-ын зарим лидерүүд ч хамрагдаж байсан. Тухайлбал, Есида Сигеру, Киси Нобусукэ. 1964 онд Икэда ЛАН-ын даргаар дахин сонгогдсон нь түүний хувьд 3 дараалан сонгогдсон том амжилт байсан.

1972 онд ерөнхий сайдын суудлын төлөөхи тэмцэлд Танака /1948 оноос Либерал намд орсон/ ялснаар ЛАН-ын дотор томоохон фракцууд үүссэн. Зарим нэг шалтгаан бол АНУ руу зүглэсэн бодлогод дургүйцсний илэрхийлэл ч байсан. Ер нь дайнаас хойшхи АНУ-Японы харилцааны төвөгтэй асуудлууд бол “аюулгүй байдлын гэрээ”, тэлгээрийн хоорондын худалдааны тэнцвэрийн асуудлууд байлаа.

ЗХУ болон бусад социалист орнууд түүний дотор БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгохыг зорьсон анхны ерөнхий сайд ч Танака байлаа. Гэвч Японы улс төрийн түүхэнд ч нэлээд скандал хийсэн ерөнхий сайдаар тодорсон. Тэрээр АНУ-ын онгоцны үйлдвэр “Локхид”-ын хэргээр парламентын 17 гишүүн, засгийн газрын 460 түшмэд холбогдсон асуудалд Танакаг 500 сая иений хахуульд орооцуулдсан. Энэ асуудлыг шүүх үйл ажиллагаа 1976 онд эхэлж 1983 онд арайхийж хаагдаж Танака 4 жилийн хорих ял сонссон. Танака бол ЛАН-ын лидер, ерөнхий сайдал томилогдсон хамгийн бага боловсролтой /ердөө 6-р ангийн / цорын ганц хүн.

1946 оны 5-р сард Хоршооллын Ардчилсан Нам /Кёдо Минското/, 1947 оны 3-р сард уг нам Ардын намтай нийлж Ардын Хоршоологчдын Нам /Какумин Кёдото/ байгуулагдаж ерөнхий нарийн бичгийн даргаар нь Мики сонгогдсон. 1950 онд дээрхи нам хэд хэдэн өөр намуудтай нэгдэж 1951 оны 1-р сард Ардын Ардчилсан Нам /ААН/ байгуулагдан мөн л Мики ерөнхий

нарийн бичгийн даргаар сонгогдсон. Харин 1952 оны 2-р сард ААН, Тариачдын холбоо, бас бус улс төрийн бүлгүүд нэгдэж Дэвшлийн Нам байгуулагдсан бөгөөд Мики ерөнхий нарийн бичгийн даргаар, 1955 онд ЛАН зохион байгуулагдахад Мики ерөнхий нарийн бичгийн даргаар тус тус сонгогдсон.

Харин 1974 оны 7-р сарын 17-нд Мики, Фукуда нар /хоёулаа Танакагийн засгийн газрын гишүүн/ ЛАН-ыг “өөрчлөн зохион байгуулах, шинэчлэх”-эд хамтран ажиллахаар тохиролцсон. Танакагийн дараагаар ЛАН-ын даргаар Мики сонгогдсон ба түүний фракц том биш ч нэлээд “зөөлрүүлэх” байр суурьтай байсан. Тийнхүү 1974 оны 12-р сарын 9-нд Мики өөрийн засгийн газраа байгуулжээ. Түүний дараа ЛАН-ын лидерүүд болох Фукуда, Охиро нар ерөнхий сайдад томилогдон 1980 онтой золгосон. 1979 онд ЛАН-ын парламентын сонгуулийн төлөөлөгчдийн танхимд 511 суудлаас 298 суудал авсан. Тиймээс бие даасан сонгогчдоос өөртөө татах шаардлага улс төрийн хүчнүүдэд гарч ирсэн.

1980 онд ЛАН эдийн засгийн зогсонги байдал, ажилгүйдэл, хахуулийн хэргээр ээлжилж хямралд орж Охиро шахалтад автан парламентын доод танхимыг тарааж 1980 оны 6-р сарын 22-нд урьдчилсан сонгууль явуулахаар бэлтгэж байгаад нас барсан. Энэ сонгуульд ЛАН 511 суудлаас 284 авсан. Охирогийн халааг Судуки Дзэнко авч жил гаруй ерөнхий сайдын албыг хашсан. Судуки бол 1947 онд ЯСН-аас парламентад сонгогдож байсан, 1948 оны 2-р сард уг намаас гарч Либерал намд орсон. 1960-аад онд ЛАН-ын удирдах зөвлөлийн дарга, Сатогийн засгийн газрын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд байсан.

Либерал Ардчилсан Нам нь (ЛАН) 1976 онд анх удаа парламентийн олонхийн суудлаа алдсан. Гэсэн хэдий ч 25 жилийн дотор хуучинсаг бөгөөд улс төрийн голлох хүч болох ЛАН нь Японыг “ер бусын” орон болгон хувиргасан. Энэхүү хандлага нь дараагийн 10 жилд буюу 1980-1990 онуудад ч зарим нэг “ороо бусгаа” үеийг эс тооцвол бараг хадгалагдсан. Үүнд: сонгогчдын дундахи рейтингийн бууралт, санхүүгийн скандалууд, татвар-төсвийн өөрчлөлтийн улмаас гарсан зөрчлүүд, АНУ-тай “хэл ам гаргах”, Японы эдийн засгийн экспансийн өдий хүртэлхи сулралт зэрэг асуудлууд. 1982 оны 10-р сарын 24-нд Накасонэ Ясухиро залгаж ерөнхий сайд, ЛАН-ын даргын суудлыг 2 удаа эзлэж 1987 онд албан тушаалаа ЛАН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Такэсита

Ноборуд шилжүүлсэн. 1983 оны сонгуульд ЛАН-ын байр суурь суларсан боловч 3 жилийн дараа 1986 онд Ясухиро Накасонэгийн удирдлага дор томоохон амжилтыг дахин олсон юм. Тэр татварын бодлогод өөрчлөлт хийх зорилт тавьсан ч тэр нь түүнийг 1987 оны сүүлчээр Нобору Такэситагаар солих шалтаг болсон. Гэвч Японы түүхэнд байгаагүй томоохон хахуулийн хэргээр тэр 1989 онд огцорсон.

Түүний дараагийн лидер нь өөрийн хувийн чанарын золиос болон огцорсон боловч Америкийн түрэмгийлэл төгсснөөс хойшхи үеийн 13 дахь ерөнхий сайд Тошики Кайфу гарч ирсэн. Тэрээр Такако Дои тэргүүтэй ЯСН-ын эсрэг тууштай зогсож чадах хүн хэмээн хүндэтгэлийг өгсөн. 1989 оны сонгуульд ЛАН нь анх удаа парламентын дээд танхимд ихэнхийн суудлыг алдсан боловч депутатуудын хагас нь дахин сонгогдож чадсан. 252 суудлаас 109 суудал, ЯСН 67 суудал авсан. Дараагийн сонгуульд ЛАН нь парламентын доод танхимд олонхийн суудлаа хадгалсан. Т.Кайфу санасныг бодоход овоо тогтож чадсан. Учир нь фермер, жижиг бизнес, эмэгтэйчүүд, гадаад худалдааны эерэг сальдо зэргээр өөрийн байр сууриа бэхжүүлсэн. Т.Кайфугийн үед ЛАН нь байр сууриа бэхжүүлэх тал дээр амжилт олсон хэдий ч өөрийн байдлыг хадгалж чадсангүй. Эдийн засгийн 5 хувийн өсөлттэй байсан ч тэр нь “японы хэмжүүрээр” дэндүү бага үзүүлэлт байв. Үл хөдлөх хөрөнгө, хувьцааныг үний бууралт ажиглагдаж эхэлсэн.

Т.Кайфуг ЛАН-ын өөр нэгэн лидер Киити Миядзава сольсон. Гэвч түүний үед сүүлийн 20 жилд гараагүй эдийн засгийн уналт гарсан явдал эрх баригч ЛАН-ын хувьд асар том цохилт боллоо. Мөн чанартаа /өөрөөр хэлбэл ЛАН дангаар ноёрхсон/ нэг намын системд улс төрийн байрыг хуваахаас илүү “картыг” тавьсан байлаа. “Хүйтэн дайн” дууссанаар Японы улс төрийн системийг маш хүчтэй “эвдрэлд” оруулсан ба Японы аюулгүй байдал, эдийн засгийн бодлогын асуудлыг зарчмын хувьд гаргаж ирсэн. II дайны дараахи олон арван жилийн туршид засгийн эрхэнд байсан ЛАН-ын давуу байдал нь зөвхөн коммунизмын эсрэг тэмцэлд тэргүүлж байсан түүний байр суурийн илэрхийлэл юм. АНУ II дайны дараа үндсэн хуулийг нь “бичиж” өгч, ардчиллын хэм хэмжээг нэвтрүүлэн, коммунизмын эсрэг хүйтэн дайнд татан оруулсан. Олон намын системтэй ч ЛАН-ын “үнэмлэхүй” лидер байр суурь нь түүнийг

өөр бусдад нэн ялангуяа ЯСН-д засгийн эрхийг алдахгүй байх гэсэн төрөлхийн “синдром”-той болгосон. Тэр ч утгаараа ЛАН нь консерватив үзэлтэй лидерүүдийн “баги” болон хувирсан нь улс төрийн дээд суудлуудыг өөр хоорондоо “чулуудсан” улс төрөөр бизнес хийхийн сонгодог утгын илэрхийлэл болсон.

1990-ээд оны эхэн гэхэд тиймэрхүү байдлын эсрэг бусад намаас бус ЛАН-ын гишүүдийн зүгээс дургүйцлээ илэрхийлэх болсон. 1992 онд Мори Хосокава ЛАН-аас гарч Японы Шинэ Намыг байгуулсан. Тэрээр удмын аристократ бөгөөд дайны өмнөх үеийн Японы улс төрийн томоохон зүтгэлтний нэг болох гүн Фумимаро Коноэгийн ач байсан. Дараа жил нь ЛАН-аас салсан Итиро Одзава, Цутому Хата нар Японы шинэчлэгдсэн Намыг байгуулсан. Уг нь тэд Шино Конэмаругийн удирдсан ЛАН дахь томоохон фракцын гишүүд байсан. 1993 оны сонгуулийн дараа ч ЛАН нь парламентад хамгийн том нам хэвээр үлдсэн. Гэвч хамгийн ашиггүй зүйл гэвэл ЛАН-аас гарсан “хүнд гарууд” болон түүний гол сөрөг хүчин болох ЯСН-ын хувьд дайны дараахи үеийн Японы түүхэнд анх удаа ЛАН-гүйгээр Хосокава тэргүүтэй эвслийн шинжтэй засгийн газрыг байгуулсан. Гэвч Хосокава өөрөө санхүүгийн скандалд өртсөн. Энэхүү “эвсэл” маань татвар ноогдуулах, сонгуулийн системийн өөрчлөлт, батлан хамгаалах бодлого зэрэгт санал зөргөөж салсгаасан. Тэрээр өөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйлсдээ хамгийн бага амжилт олж /хүнд сурталтай тэмцэх, засгийн газрын төвлөрлийг арилгах, японы зах зээлийг гадаалдын өрсөлдөгчдөд нээх г.м./ жил хүрэхгүй хугацааны дотор түүнийг Гадаад Хэргийн сайд байсан Хата нь сольсон. Юуны өмнө Хатаг Одзавагийн үзэл санааг дэлгэрүүлэгч маягтай авч үздэг байсан. Одзава бол хор найруулах их мастер, томоохон автократ төдийгүй, Токиогийн засаглалын шинэчлэгдсэн буюу шинэ хэлбэрийн бэлэг тэмдэг мэтээр авч үздэг. Хатагийн засгийн газар дайны дараахи Японы засгийн газруудаас хамгийн хэврэг нь байлаа. ЯСН нь амлаж байсан дэмжлэгээсээ маш түргэн татгалзан өөрийн “ясны дайсан” болох ЛАН-тай түүний “болчимгүй” өөрчлөгчдийг зайлуулах томоохон наймааг хийж амжсан.

ЛАН нь социалист Томиити Мураямад ерөнхий сайдын суудлыг өгч байж “засгаа” буцааж авсан. Харин эвслийн засгийн эдийн засгийн программ нь 1995 онд Кобед болсон газар хөдлөлтийн

улмаас хэрэгжих боломжгүй болж /сэргээн босгох бүх зардал засгийн газрын нуруун дээр ирсэн/, ерөнхий сайд байх хугацаанд түүний нэр хүнд тасралтгүй буурсаар 18 сарын дараа буюу 1996 оны эхний 7 хоногт Мураяма огцорсон. “Хүйтэн дайн”-ны төгсгөлд Япон нь эдийн засгийн супер гүрэн болон хувирсан /Европын аль ч орныг хойноо орхиж, АНУ-тай өрсөлдөж чадахуйц/

“Уолл стрит журнал”-ын 1991 оны 9-р сарын дугаарт бичснээс үзвэл дэлхийн 100 том банкны 29 нь японых, 12 германых, 10 францынх, 9 АНУ-ын, 9 италийнх, дэлхийн 5 том даатгалын компаний 4 нь японых. Японы гадаад дахь капитал 1 трлн. ам. доллараас давлаа. Өнөөдөр япончуудын 50 хувь нь л АНУ-ын цэргийн зонтикийг гол болгож байхад 50 хувь нь түүнийг үгүйсгэж байна. Японы бизнесменүүдийн 80 хувь нь Окинава дахь АНУ-ын цэргийн тоог хорогдуулах саналтай байгаа. Ази дахь эдийн засгийн нөлөөний хүрээг хуваахдаа АНУ, Япон хоёр өрсөлдөж байгаа нь ч нууц биш.

1990 оны 9-р сард ЛАН, ЯСН-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Пхеньянд айлчилж БНАСАУ-тай харилцааг хэвийн болгох талаар хэлэлцээр хийх хүсэлт тавьсан. Уг айлчлалын хүрээнд гаргасан хамтарсан мэдэгдэлд хоёр тал аль болох түргэн хугацаанд дипломат харилцаа тогтоох, хоёр Солонгосыг тайван замаар нэгтгэх, цөмийн аюулыг зайлуулах, 3-н намын харилцааг улам бэхжүүлэх зэргүүд тусгагдсан нь Азид улс төрийн уур амьсгалыг зөөлрүүлэх том алхам болсон.

1991 оны 11-р сарын 27-нд парламентын дэмжлэг олж НҮБ-ын энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд Япон оролцох болсон нь дэлхийн II дайнаас хойш өөрийн цэргийн хүчээ гадаад гаргасан анхны алхам байлаа. Бидний сайн мэдэх “Курилын” арлуудын асуудлаар ч “хатуу байр” суурьтнууд улс төрийн бүх намуудын дотор, нэн ялангуяа ЛАН-ын дотор илүү ч байгаа. Тэд зөвхөн Курилын арлууд төдийгүй бүр Сахалины өмнөд хэсэг рүү ч “дайрч” байгаа. Харин социалистууд, коммунистууд зөвхөн Өмнөд, Хойд Курилаар л хязгаарлаж байгаа. Зарим нэгэн мэдээгээр ЛАН-ын нэр нөлөө бүхий зүтгэлтнүүд Ельцинд нууц илгээлт явуулж түүнд “Токиод Миядзаваг бодвол илүү уян хатан хүн” ирэх хүртэл түүнтэй холбогдохгүй байхыг хүссэн аж.

ДУГНЭЛТ:

1. ЛАН нь барууны чиглэлийн консерватив нам
2. ЛАН нь АНУ-Японы харилцааг илүү ойртуулж, Америкийн цэргийн зонтикийг хүлээн зөвшөөрсөн, эдийн засгийн харилцаанд тэнцвэрийг хадгалахын төлөө улс төрийн хүч
3. ЛАН нь дэлхийн II дайнаас хойш дангаар засгийн эрхийг барьсан ганц нам
4. ЛАН нь санхүүгийн болон бусад асуудлаар хамгийн их хэл аманд өртсөн хүч
5. ЛАН нь дэлхийн II дайнд Японы зүгээс бусад ард түмэнд учруулсан хор хохиролын төлөө буруугаа хүлээсэн улс төрийн хүчин
6. ЛАН нь Японыг дэлхийн эдийн засгийн нэг гол цөм болгон хувиргасан улс төрийн хүч
7. ЛАН дотроо маш олон, хүчтэй фракцитай, тэдгээрийн тохиролцоонд хүрэх асуудал тогтвортой байдлын нь эх сурвалж

АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. А.С.Селишев. Японская экспансия. Люди и идеи. Иркутск, 1993
2. А.П. Марков. Россия-Япония. –М, 1996
3. Питер Кальвокоресси. Мировая политика после 1945 года. М, 2000